



САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2025 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 68

Улаанбаатар хот

Журам батлах тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.2, 6.2.1, Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4, 14 дүгээр зүйлийн 14.6 дахь хэсгийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Банк бус санхүүгийн үйл ажиллагааны болон зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг тооцож, хяналт тавих журам”-ыг нэгдүгээр хавсралтаар, “Банк бус санхүүгийн байгууллагын хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг нэмэгдүүлэх, хорогдуулах, шинээр хувьцаа гаргах, худалдах, шилжүүлэхэд мөрдөх журам”-ыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын албанд даалгасугай.

ДАРГА



Т.ЖАМБААЖАМЦ

1518000133

**БАНК БУС САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГЫН ХУВЬ НИЙЛҮҮЛСЭН ХӨРӨНГИЙН
ХЭМЖЭЭГ НЭМЭГДҮҮЛЭХ, ХОРОГДУУЛАХ, ШИНЭЭР ХУВЬЦАА ГАРГАХ,
ХУДАЛДАХ, ШИЛЖҮҮЛЭХЭД МӨРДӨХ ЖУРАМ**

Нэг.Нийтлэг үндэслэл

1.1.Банк бус санхүүгийн байгууллага (цаашид “ББСБ” гэх)-ын хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг нэмэгдүүлэх, хорогдуулах, шинээр хувьцаа гаргах, худалдах, шилжүүлэх, хувьцаа эзэмшигчдийн бүтэц, бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах, хоёрдогч өглөгөөр эх үүсвэр татахтай холбоотой үүссэн харилцааг энэ журмаар зохицуулна.

**Хоёр.Хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг нэмэгдүүлэх, хорогдуулах, хувьцааг худалдах,
шилжүүлэхэд тавигдах шаардлага**

2.1.Эцсийн өмчлөгч, хувьцаа эзэмшигчээс оруулах мөнгөн хөрөнгө нь бусдын өмнө үүрэг хүлээгээгүй, тухайн этгээд, түүнтэй холбогдох этгээдийн хууль ёсны орлогоор бүрдүүлсэн, татварын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад тайлагнасан орлого байна.

2.2.Хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ, бүтэц, хувьцаа эзэмшигчдийн бүрэлдэхүүнд Компанийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.2-т зааснаас гадна дараах байдлаар өөрчлөлт оруулна:

2.2.1.хувьцаа эзэмшигч нь хувьцаагаа бэлэглэх, өвлүүлэх, эсхүл бусад хувьцаа эзэмшигчид болон гуравдагч этгээдэд худалдах;

2.2.2.хугацааны эцэст хувьцаанд хөрвүүлэх хоёрдогч өглөг;

2.2.3.хууль болон холбогдох журамд заасан бусад хэлбэрээр нэмэгдүүлэх;

2.2.4.Хорооноос тогтоосон хувь нийлүүлсэн хөрөнгийн доод хэмжээ, зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүдийг хангаж, санхүү, төлбөрийн чадварт сөргөөр нөлөөлөхгүй, хувьцаа эзэмшигчдийн бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулснаар бусад хувьцаа эзэмшигч, харилцагчдад хохирол учруулахгүй бол хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг хорогдуулах.

2.3.Энэ журмын 2.2.1-д заасны дагуу хувьцаа эзэмшигч нь өөрийн эзэмшлийн нэгж хувьцааг нэрлэсэн үнээс багаар худалдах тохиолдолд хөрөнгийн үнэлгээний компаниар нэгж хувьцааны үнэлгээг тогтоолгосон байна.

2.4.Нээлттэй хувьцаат компани хэлбэрээр үйл ажиллагаа явуулж буй ББСБ нь хаалттай хүрээнд нэмж хувьцаа гаргах, аливаа этгээд дангаар болон холбогдох этгээдийн хамт ББСБ-ын нөлөө бүхий хувьцаа эзэмшигч болох, ББСБ-ын нөлөө бүхий хувьцаа эзэмшигчийн хувьцааны хэмжээ, бүтэцэд өөрчлөлт оруулах тохиолдолд энэ журмын 2.1-д заасан шаардлагыг хангах ба Хорооны шийдвэр гарсны дараа холбогдох гүйлгээг хийнэ.

2.5.Хувьцаа эзэмшигчдийн бүрэлдэхүүн, хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ, бүтэцэд өөрчлөлт оруулах зөвшөөрлийн хүсэлт гаргаж буй ББСБ хувь нийлүүлэх мөнгөн хөрөнгийг байршуулсан хувьцаа эзэмшигчийн данснаас зарлагын гүйлгээ хийхгүй бөгөөд Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуулийн 14.5-д заасны дагуу Хорооны дарга шийдвэрлэхээс өмнө дансны үлдэгдэлд өөрчлөлт оруулсан эсэхийг дахин баталгаажуулж болно.

2.6.Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.5-д заасны дагуу

ББСБ нь хувьцаа эзэмшигчдийн бүрэлдэхүүн, хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ, бүтцэд өөрчлөлт оруулах тухай бүр шийдвэр гарсны дараа холбогдох гүйлгээг хийнэ.

Гурав.Хоёрдогч өглөгөөр эх үүсвэр татахад тавигдах шаардлага

3.1.ББСБ өөрийн хөрөнгийн хэмжээг нэмэгдүүлэх зорилгоор хоёрдогч өглөг хэлбэрээр энэ журмын 2.1-д заасан шаардлагыг хангасан мөнгөн хөрөнгийг гуравдагч этгээдээс гэрээний үндсэн дээр гурваас доошгүй жилийн хугацаатай татан төвлөрүүлэхээр шийдвэрлэсэн тохиолдолд хувьцаа эзэмшигчдийн хурлын тэмдэглэл, шийдвэр, хоёрдогч өглөгийн гэрээ, хөрөнгө оруулж буй мөнгөн хөрөнгийн гарал үүсэл, хууль ёсны орлогоос бүрдэж буйг нотлох баримт бичгийн хамт ажлын 10 хоногийн өмнө Хороонд урьдчилан мэдэгдэнэ.

3.2.Хоёрдогч өглөгийн гэрээнд дараах зүйлийг заавал тусгана:

3.2.1.гэрээ байгуулсан огноо, гэрээний дугаар;

3.2.2.хоёрдогч өглөг байршуулах этгээдийн нэр, иргэний болон улсын бүртгэлийн дугаар, хаяг утас;

3.2.3.хоёрдогч өглөгөөр байршуулах мөнгөн хөрөнгийн хэмжээ, гэрээний хүү, хугацаа;

3.2.4.хоёрдогч өглөгийг хувьцаанд хөрвүүлэх нөхцөл;

3.2.5.талуудын эрх, үүрэг, хүлээх хариуцлага.

3.3.Хоёрдогч өглөгийг хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэрийг үндэслэн хувьцаанд хөрвүүлэх эсэх талаарх шийдвэрийг Хороонд мэдэгдэнэ.

3.4.Банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосон, дампуурсан, төлбөрийн чадваргүй болсныг зарласан, өөрчлөн байгуулснаас бусад тохиолдолд хоёрдогч өглөгийн үндсэн өрийг хугацаанаас нь өмнө барагдуулахгүй.

---oOo---